

Хосмог сургалт, хөдөлмөр эрхлэлт, суралцагчийн хөгжлийн асуудал хариуцсан шинжээч, Энхболд Эрдэнэбилэг

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх	2023 оны хэрэгжилтийн байдлаар	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох чиг үүрэгт хамааралтай заалтын хэрэгжилтийг 2024 оны байдлаар боловсруулж удирдлагад танилцуулан заасан хугацаанд нь цахим системд оруулсан. 2024 онд Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хэсэгт хяналтад байгаа 96	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хуулийн заалтаас нэг удаагийн болон хэрэгжиж дууссан заалт байвал хасуулах заалтыг нэг бүрчлэн шүүж саналаа ТЗУГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. 2024 оны 12 дугаар сард Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг тухайд нь тайлагнав. Мөн бүрэн хэрэгжсэн заалтыг хасуулах арга хэмжээ авсны үр дүнд 2024 оны эцэс гэхэд 15 заалтын биелэлтийг гаргав. 2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Монголын багш нарын VIII их хурал" 2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан зохион бөгөөд "Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар хуралдаан"-ыг удирдан амжилттай зохион байгуулж, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Нэгдсэн	
--	--	--	--	--	---	--

					хуралдаанд танилцуулсан. "МОНГОЛЫН БАГШ НАРЫН VIII ИХ ХУРАЛ" -ийн үр дүнд Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 92 дугаар тогтоолоор "Багшийн гурван тулгуурт бодлого цогц арга хэмжээг батлах тухай" батлагдаж Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 8 дахь заалтын хэрэгжилтийг давхар тайлагнан ажиллав. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын яам болон ГБХНХЯ-ны хамтарсан "Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага", "Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам", "Боловсролын	
--	--	--	--	--	--	--

					сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын өөрийн үнэлгээний асуумж”, “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсэг, "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын үндсэн чиглэл (2024-2028) боловсруулах" ажлын хэсэгт гишүүнээр ажилласан. Хавсралт: 3 файл		
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг заасан хугацаанд нь цахим системд тайлагнаж ажилласан. Тухайлбал, Дэлхийн ур чадварын тэмцээнтэй холбоотой заалтын биелэлтийг дараах байдлаар тайлагнав. Боловсролын яам нь эрхлэх асуудлын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр анхаарч ажиллаж байгаа бөгөөд “Мэргэжлийн боловсрол, сургалт-түншлэл” ТББ-тай 2022 оны 05 дугаар сард МБСХ-2002/21 дугаар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсны дагуу БШУ-ны сайдын А/198 дугаар тушаалаар "Тэмцээн зохион байгуулах журам"-ыг, тэмцээний 8 мэргэжлийн удирдамжийг батлуулсан. Францын Леон хотноо 2024 онд зохион байгуулагдсан “Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд 60 мэргэжлээр 1500 гаруй улс орны шилдэг залуус мэргэжлийн ур чадвараараа өрсөлдсөн бөгөөд Монгол Улсаа төлөөлж мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын	гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---------------------------------

					байгууллагын шилдэг, багш суралцагчид 5 дахь удаагаа оролцсон. "Дэлхийн ур чадвар-Лион 2024" тэмцээний гагнуурын төрөлд 42 эксперт багш 39 оролцогч ур чадвар, мэдлэгээрээ өрсөлдөж тус тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн Өмнөговь политехник коллежийн суралцагч Б.Чухал оролцсон бөгөөд тэрбээр эх орноо төлөөлөн тангараг өргөж, "Best of nation" шагналын эзэн болсон. Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг 2025-2028 он хүртэл жил тус бүрээр боловсруулж БНБТ-ийн газарт хүргүүлсэн. Үүнд эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой	
--	--	--	--	--	---	--

					уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог, ажлын байрны сургалтыг нэвтрүүлэх, суралцагчийн хөгжил хамгаалал, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр заалтуудыг боловсруулж тусгасан. Хавсралт: 3 файл		
3	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	“Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэгт хамаарах 9 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг заасан хугацаанд нь цахим системд тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	тайлагнах				Тухайлбал, "Мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллах, түншлэлийг бэхжүүлэн зарим төрлийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлж, бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах" зорилтын тухайд БШУС-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/329 дүгээр тушаалаар Хосмог сургалтын тогтолцооны удирдлага, зохион байгуулалт, сургалт, үнэлгээ, чанарын хэрэгжилтийг хангах зорилготой Менежментийн хороог Боловсролын яам, ГБХНХЯ, МҮХАҮТ, МҮЭ-ийн холбоо, Ур чадвар, үйлдвэрлэлийн холбоо, Трансвест Монголиа ХХК, Ньюком групп ХХК, Премиум групп, ААН байгууллага, ТББ-ын бүрэлдэхүүнтэй байгуулан талуудтай хамтран ажиллаж байгаа талаар тайланд тусгасан.	12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	-----------	--	--	--	---	----------	--

					Мөн "Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна." заалтын тухайд МБТБСТХ-ын дагуу сургалтын байгууллага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшнийг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохируулан сургалтын хөтөлбөрөө боловсруулан зохион байгуулж Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 200 дугаар тогтоол" Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай"-ийн дагуу тусгай хэрэгцээт суралцагчид ногдох хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлэн		
--	--	--	--	--	--	--	--

					олгож байгаа талаар тайланд тусгасан. Үүнээс гадна сургалтын байгууллагын санхүүжилтийг төгөлдөржүүлэн, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад дэмжих, Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн хөтөлбөрүүдийн ангиллыг элсэлтийн бодлого, ажиллах хүчний тооцоотой уялдуулж шинэчлэх зэрэг заалтуудын биелэлтийг хангаж, хугацаанд нь тайлагнаж ажиллав. Хавсралт: 1 файл		
4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан салбарын холбогдох чиг үүрэгт хамаарах заалтын биелэлтийг заасан хугацаанд нь цахим системд тайлагнаж ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					Тухайлбал “Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь” зорилтын тухайд 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тодорхойлж, үүнтэй уялдуулж сургалтын байгууллагуудад элсэлтийн бодлоготой холбоотой мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллаж байгаа талаар тусгасан. Энэхүү суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгаагаар 12701 төгсөгч мэргэжлээрээ болон өөр мэргэжлээр хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн судалгааг Боловсролын ерөнхий газраас гаргасан ба 2022 онд 2020-2022 оны хичээлийн жилийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	---

					төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 58.8 хувьтай байсан бол 2024 онд 2022-2023 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 63.7 буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа дүгнэлт гарсан. Энэ нь Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 61.8-аас 2 хувиар илүү өссөн үзүүлэлттэй байгаа талаар тайланд тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласан. Хавсралт: 1 файл		
5	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж	Холбогдох бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь тайлагнасан байна.	2023 оны тайлан	Холбогдох бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь тайлагнасан байна.	Бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэгт хамаарах зорилт арга хэмжээ болон хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд тайлагнаж ажилласан. Тухайлбал, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 Монгол	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

	тайлагнах				Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Жөндөрийн үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлан зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэгт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнаж ажилласан. Хавсралт: 6 файл		
1.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хөгжил, сургалтын чанар, багш, суралцагчийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг боловсронгуй болгох удирдлага, зохион байгуулалтаар хангах							
6	Мэргэжлийн болон	Сайдын тушаалаар	Журам, аргачлалын	Хэрэгжилтийг хангуулах талаар Боловсролын	“Мэргэжлийн болон техникийн	1-р сар, 2-р сар,	Өөрийн үнэлгээ:

	техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлт, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах тухай журмыг батлуулах	батлагдсан байна.	төслийг боловсруулсан.	ерөнхий газартай хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.	боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлт, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах тухай журам"-ыг БШУС-ын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, журамд заасан аргачлал, шалгуурын дагуу боловсруулж нийт 66 сургалтын байгууллагад 27.690 суралцагч элсүүлэхээр хяналтын тоог төлөвлөн БШУС-ын 2024 оны 06 дугаар сарын 24-ний А/313 дугаар тушаалаар батлуулсан. Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--------------------------	-------------------------------	--	---	--	---

					А/49 дүгээр тушаалаар Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн баталсантай холбогдуулан дээрх 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоог шинэчилсэн индексийн дагуу дахин боловсруулж 2024 оны 11 дүгээр сарын 11-нд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөлийн 15 гишүүнд хүргүүлж танилцуулсан бөгөөд журамд заасны дагуу мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн элсэлтийн хяналтын тоог шинэчлэх тухай тушаалын төслийг удирдлагуудаар хянуулан Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/217 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалыг	
--	--	--	--	--	---	--

					Боловсролын ерөнхий газарт газрын даргын албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллав. Хавсралт: 5 файл		
7	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журмыг батлуулах	Сайдын тушаалаар батлагдсан байна.	Журам, загварын төслийг боловсруулсан.	Хэрэгжилтийг хангуулах талаар Боловсролын ерөнхий газартай хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.	“Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журам”-ыг БШУС-ын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/13 дугаар тушаалаар баталсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөгчдийн баримт бичиг олгох асуудлаар Боловсролын ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж зөвлөмж, мэдээлэл хүргэсэн. Мөн журмын хэрэгжилтийн хүрээнд боловсролын баримт бичгээ гээгдүүлсэн, нөхөн авах хүсэлт ирүүлсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					суралцагчдын өргөдөл хүсэлтийг шийдвэрлэхийн зэрэгцээ цахим шуудан болон утсаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мэргэжлийн болон техникийн боловсролын 2023-2024 оны хаврын төгсөлтийн үнэлгээнд 69 сургуулиас 59 сургуулийн 10111 суралцагч төгсөлтийн үнэлгээнд албан ёсоор хамрагдаж, үнэлгээний гүйцэтгэл улсын дунджаар онол-87.9%, ур чадвар-93%-тай тус тус үнэлэгдсэн байна. (БҮТ-ийн тайлангаас). 2024-2025 оны өвлийн төгсөлтийн үнэлгээнд 46 сургуулийн техникийн боловсролын 506, мэргэжлийн боловсрол олгох сургалтын 1 жил-203, 2,5 жил-6464 суралцагч нийт 405 хөтөлбөрөөр 7173 суралцагч хамрагдана. Өвлийн төгсөлтийн шалгалттай холбоотой онол, ур	
--	--	--	--	--	--	--

					чадварын үнэлгээний төлөвлөө боловсруулах, системийн бүртгэл, хэвлэлттэй холбоотой Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран ажилласан. Хавсралт: 2 файл		
8	Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулах	Сайдын тушаалаар батлагдсан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиар шинээр тусгагдсан заалт	Сайдын тушаалаар батлагдсан байна.	“Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журам”-ыг БШУС-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/330 дугаар тушаалаар батлуулсан. Хосмог сургалт, ажлын байран дахь сургалтыг нэвтрүүлэх чиглэлээр Боловсролын яам, МҮХАҮТ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2024 оны 03 сарын 18-нд байгуулсан. Мөн ГОУХАН /GIZ/-ийн “Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалт-2” төслөөс хосмог сургалтыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байна. Талуудын хамтын ажиллагааны хүрээнд хосмог сургалтыг удирдан зохион байгуулах "Хосмог сургалтын төслийн менежментийн хороо" ажлын хэсгийг БШУС-ын 2024 оны А/329 дүгээр тушаалаар баталсан. Менежментийн хороо болон хамтран ажиллагч талуудын хүрээнд 16 удаагийн хурал, хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулсан бөгөөд хосмог сургалт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, журмын танилцуулга, 2024-2025 оны хичээлийн жилд хосмог сургалт зохион байгуулах дэд ажлын хэсгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэж, үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хангаж ажилласан. Хосмог сургалтыг 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн Налайх, Дархан политехник коллежид цахилгаан	
--	--	--	--	--	---	--

					дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай хамтран, Ховд аймгийн “Хөгжил” политехник коллежид “Вестерн холлд” ХХК-тай хамтран, “Скиллс тек” МБС-д “Оюу толгой” ХХК-тай хамтран хэрэгжүүлж нийт 100 гаруй суралцагчийг хамруулж байна. Сургалтын нээлтийг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Налайх, Дархан политехник коллежид зохион байгуулж нээлтэнд Боловсролын сайд П.Наранбаяр, МҮХАҮТ-ын дэд захирал Д.Магнайбаатар, ГОУХАН (GIZ), Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК оролцов. Нээлтийн үеэр Боловсролын сайд П.Наранбаяр Цаашид “Алсын хараа-2050”, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан улс орны бүтээн	
--	--	--	--	--	---	--

					байгуулалтын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтан, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг хосмог сургалтаар бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллана” гэдгийг онцолсон. Хавсралт: 27 файл		
1.5. Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбох, мэдээллийн нэгдсэн сүлжээг өргөтгөх, нэгж байгууллагын дотоод сүлжээний орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах							
9	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн системийг шинэчлэх ажлыг эхлүүлэх	Системийн шинэчлэгдсэн модулийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/228 дугаар тушаалаар Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж Цахим боловсролын газартай хамтран ажилласан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийг шинэчлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд цахим мэдээллийн системийн статистик мэдээллийн маягтын загварыг боловсруулахад газрын хүрээнд хэлэлцэж саналаа Цахим бодлогын газарт хүргүүлсэн. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

			ажиллаж, системийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээг хийн хөгжүүлэх ажлын даалгаврыг эхний байдлаар боловсруулсан. Зорилтот түвшин / Эхний хагас жил / Мэргэжлийн болон техникийн боловсролын		хууль, хөтөлбөр, төлөвлөгөөний дүрэм журам шинэчлэгдэн батлагдсан, боловсролын салбарын мэдээллийн системүүдтэй уялдаа холбоогүй, бүтцийн хувьд ялгаатай, өөр программын хэл дээр бичигдсэнтэй холбоотойгоор салбарын систем хооронд мэдээлэл солилцоход хүндрэл учирдаг тул тус системийг шинэчлэх шаардлага үүссэн. Иймд БШУС-ын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр А/76 дугаар бүхий “Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын	
--	--	--	---	--	---	--

					удирдлагын мэдээллийн системээр мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөлт болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ хийх статистик тайлан мэдээг системээр нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлэхээр системийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулсан. Тус ажлын даалгаврын дагуу ерөнхий үйл ажиллагааны процесс, шинэ системийн модулийн суурь судалгааг хийж, системийн цар хүрээний баримт бичгийг боловсруулсан. Жилийн эцсийн байдлаар системийн байгууллагын нэгтгэл, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын агуулга тестийн түвшинд хөгжүүлэгдэн суурь дата мэдээллийг	
--	--	--	--	--	--	--

					хөрвүүлэх ажил хийгдэж байна. 2024 оны 12 дугаар сард суралцагчийн модуль, ирц, дүн үнэлгээний бүртгэл, төгсөлт, боловсролын баримт бичиг зэрэг модулийг тестийн түвшинд ажиллуулж Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудтай хамтарсан тест хийж байна.		
10	Боловсрол сургалтын байгууллагад сургуулийн удирдлагын болон сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	Мэргэжлийн болон техникийн боловсролын системийг Боловсролын удирдлагын мэдээллийн систем / https://www.esis.edu.mn/ , https://hemis.edu.mn/ , Төрийн мэдээлэл солилцооны хур системтэй холбож мэдээлэл солилцох	-	Мэргэжлийн болон техникийн боловсролын системийг Боловсролын удирдлагын мэдээллийн систем / https://www.esis.edu.mn/ , https://hemis.edu.mn/ , Төрийн мэдээлэл солилцооны хур системтэй холбож мэдээллийг солилцох хөгжүүлэлт хийгдсэн байна. Цахим боловсролын газар, БМТТ-тэй хамтран ажилласан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, хөтөлбөр, төлөвлөгөөний дүрэм журам шинэчлэгдэн батлагдсан, боловсролын салбарын мэдээллийн системүүдтэй уялдаа холбоогүй, бүтцийн хувьд ялгаатай, өөр программын хэл дээр бичигдсэнтэй холбоотойгоор салбарын систем хооронд мэдээлэл солилцоход хүндрэл учирдаг тул тус системийг шинэчлэх шаардлага үүссэн. Иймд БШУС-ын 2024	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					оны 02 дугаар сарын 22-ны өдөр А/76 дугаар бүхий “Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын удирдлагын мэдээллийн системээр мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөлт болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ хийх статистик тайлан мэдээг системээр нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлэхээр системийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулсан. Тус	
--	--	--	--	--	---	--

					ажлын даалгаврын дагуу ерөнхий үйл ажиллагааны процесс, шинэ системийн модулийн суурь судалгааг хийж, системийн цар хүрээний баримт бичгийг боловсруулсан. Жилийн эцсийн байдлаар системийн байгууллагын нэгтгэл, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын агуулга тестийн түвшинд хөгжүүлэгдэн суурь дата мэдээллийг хөрвүүлэх ажил хийгдэж байна. 2024 оны 12 дугаар сард суралцагчийн модуль, ирц, дүн үнэлгээний бүртгэл, төгсөлт, боловсролын баримт бичиг зэрэг модулийг тестийн түвшинд ажиллуулж Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудтай хамтарсан тест хийж байна.		
--	--	--	--	--	---	--	--

1.6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

11	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах	Мэдээллийн хэрэгжилтийн хувь тоо,	2023 оны байршсан мэдээлэл	1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Салбарын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, зохион байгуулсан ажлын талаар Боловсролын яамны болон бусад мэдээллийн суваг, цахим хаягаар дамжуулан олон нийтэд нээлттэй танилцуулж ажилласан. Мөн утсаар болон цахим хаягаар зөвлөгөө мэдээлэл авах хүсэлтэй иргэдэд нээлттэй мэдээллийг хүргэж, салбарын бодлого, зорилт, батлагдсан дүрэм, журам, цаг үеийн үйл ажиллагааг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлж ажиллав. Мөн салбарын хэмжээнд боловсруулан батлагдсан дүрэм, журмын төсөлд иргэд олон нийтээс нээлттэй санал авах танилцуулах зорилгоор Боловсролын яамны цахим хуудсанд байршуулж санал авдаг. Тухайлбал, “Хосмог ажлын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	---	-----------------------------------	----------------------------	--	---	--	--

					байран дахь сургалтын журам"-ын төслийг яамны сайтад байршуулж санал авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн мэргэжлийн болон техникийн боловсролын салбартай холбоотой иргэдээс асууж тодруулдаг түгээмэл асуулт, хариултын мэдээллийг газрын түвшинд боловсруулж Боловсролын яамны сайтад байршуулахаар холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Үүнд суралцагчийн элсэлт, боловсролын баримт бичгийн нөхөн олголт, суралцагчийн тэтгэлэг, багшийн цалин урамшуулал, нэмэгдэлтэй холбоотой асуултыг хариултын хамт боловсруулсан. Хосмог сургалтыг 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн Налайх, Дархан, Ховд аймгийн "Хөгжил" политехник коллеж, "Скиллс тек" мэргэжлийн	
--	--	--	--	--	--	--

					боловсролын сургуульд хэрэгжүүлж эхлэж байгаатай холбоотой 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Налайх, Дархан политехник коллежид зохион байгуулсан сургалтын нээлтийн үйл ажиллагаагаар дамжуулж хосмог, ажлын байран дахь сургалтыг иргэд, олон нийт, ажил олгогч компани, аж ахуйн нэгж байгууллага, сургалтын байгууллагуудад сурталчлан таниулах үйл ажиллагааг Боловсролын яам болон МҮХАҮТ хэвлэл мэдээллийн албанаас зохион байгуулсан. Үүний дагуу холбогдох албаны хүмүүс болон сургалтад хамрагдаж буй суралцагч, дадлагажуулагч багш нарын зүгээс мэдээлэл танилцуулгыг бэлтгэн Боловсролын яамны цахим хуудсаар олон нийтэд танилцуулж түгээн дэлгэрүүлсэн. Нийт 12 мэдээллийн	
--	--	--	--	--	--	--

					сүвгээр олон нийтэд мэдээллийг хүргэсэн байна. Хавсралт: 15 файл		
3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
12	2024 онд ирсэн албан бичгийг хугацаанд нь архивлах, хянасан болон шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэн ажиллах	Архивласан боть хянасан болон шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо	2023 оны тайлан	2024 онд ирсэн албан бичгийг хугацаанд нь архивлаж, албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.	Албан бичиг болон өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох хариуг албан бичгээр хүргүүлж, шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллагатай утсаар холбогдож нэмэлт мэдээлэл тодруулга авч, холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэж ажилласан. 2024 онд нийт 134 албан бичиг, 12 өргөдлийг шийдвэрлэж, 5 боть болгож архивласан. Ирсэн ихэнх өргөдөл, гомдлын хувьд суралцагчийн тэтгэлэг олголт, үйлдвэрийн дадлагын цалин, урамшуулалтай холбоотой байсан бөгөөд холбогдох хууль, журмын дагуу	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шийдвэрлэж, иргэнд хариуг өгч шийдвэрлэсэн. Мөн яам, сургалтын байгууллага, бусад төрийн байгууллага, яамны дотоод нэгж хэлтэс, газруудаас ирсэн албан бичгийг холбогдох хууль журмын дагуу судлан хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Тухайлбал нийт 69 сургалтын байгууллагуудаас элсэлтийн хяналтын тоог батлуулахаар ирүүлсэн (журамд нийцүүлэх, хяналтын тоог алдаатай боловсруулсныг буцааж дахин шинэчилж авсан албан бичиг мөн орно) албан бичгүүдийг журам, тусгай зөвшөөрөлтэй уялдуулан хянаж, Боловсролын сайдын тушаалд тусган батлуулсан. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүй дотоод хэргийн сайд, Батлан хамгаалахын сайд, Аж үйлдвэр эрдэс	
--	--	--	--	--	--	--

					баялгийн сайд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, ОХУ-ын элчин сайдын яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон УИХ- ын зарим гишүүдээс ирүүлсэн хамтарсан журам боловсруулах, хуулийн төсөлд санал авах, журмын төсөлд санал авах, тайлан мэдээлэл авах, хамтран ажиллах, уулзалт хэлэлцүүлэгт мэдээлэл бэлтгэн оролцохтой холбоотой албан бичгүүдийг судлан холбогдох мэдээлэл, тайлан, саналыг боловсруулан албан бичгээр хүргүүлж хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Ирсэн, явуулсан албан бичиг болон холбогдох баримт бичгийг архивлан товъёог, жагсаалт үүсгэж хянаж ажилладаг.	
--	--	--	--	--	---	--

					Хугацаа хэтрүүлсэн болон шийдвэрлээгүй албан бичиг, өргөдөл гомдол байхгүй болно. Хавсралт: 2 файл		
3.2. Хосмог сургалтын менежментийн хорооны нарийн бичгийн үүргийн дагуу хурал, сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, оролцогч талуудтай хамтран ажиллана.							
13	Хосмог сургалтын менежментийн хорооны хурал, сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан хурал, сургалт, арга хэмжээ	2023 оны тайлан	Хосмог сургалтын менежментийн хорооны хурал, сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.	Хосмог сургалтын менежментийн хороо болон хамтран хэрэгжүүлж буй талуудын хүрээнд 16 удаагийн хурал, хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулсан. Үүнд: 2024 оны 03 сарын 29-нд Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах ажлын хүрээнд хамтарсан төсөл хэрэгжүүлж буй GIZ-ийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол сургалт II” төслийн багийн уулзалт, 2024 оны 04 сарын 02-нд хосмог сургалтын менежментийн хорооны дүрэм, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					уулзалт, 2024 оны 04 сарын 08-нд хосмог сургалтын менежментийн хорооны дүрэм, бүтэц, чиг үүргийн талаар Скиллстек ХХК-ийн зөвлөх багтай уулзалт, 2024 оны 04 сарын 11-нд хосмог сургалт, ажлын байран дахь сургалтын журам боловсруулах ажлын 2024 оны төлөвлөгөө, төслийн удирдах хороо, менежментийн хорооны бүрэлдэхүүн, чиг үүргийг боловсруулж, санал солилцох уулзалт, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр БШУЯ-ны Соёмбо танхимд хосмог сургалтын зөвлөлдөх уулзалт, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр БШУЯ-ны Соёмбо танхимд “Мэргэжлийн болон техникийн боловсролын хосмог сургалтын журмыг танилцуулах, санал солилцох хэлэлцүүлэг уулзалт, 2024 оны 06 сарын 25-нд журам” болон менежментийн	
--	--	--	--	--	--	--

					хорооны дүрмийг уялдуулан боловсруулах уулзалт хэлэлцүүлэг, 2024 оны 06 сарын 19-нд МҮХАҮТ-ийн ерөнхийлөгчтэй хосмог сургалтын хамтын ажиллагааны явцыг танилцуулах уулзалт, БНХАУ-ын Бээжин, Шанхай хотод 2024 оны 09 сарын 22-27-нд мэргэжлийн боловсролын хосмог сургалтын туршлага судлах арга хэмжээ, Мэргэжлийн багш, үйлдвэрлэлийн дадлагажуулагчийг өндөр хүчдэлийн техникийн хосмог сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чиглэлээр мэргэшүүлэх сургалт зэргийг зохион байгуулсан. Хавсралт: 27 файл		
3.3. Боловсролын салбарын томоохон арга хэмжээ, мэргэжилтэн бэлтгэх тогтолцооны шинэчлэл, тулгамдаж буй асуудал, гарц шийдлийн талаар төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн багш, удирдах ажилтнуудыг оролцуулсан холбогдох арга хэмжээ, сургалт, семинарыг зохион байгуулах, хууль, журам, дүрмийг сурталчлан таниулах.							
14	Боловсролын салбарын	Арга хэмжээ, сургалт, семинарыг зохион	2023 оны тайлан	Арга хэмжээ, сургалт, семинар зохион	Мэргэжлийн болон техникийн	1-р сар, 2-р сар,	Өөрийн үнэлгээ:

томоохон арга хэмжээ, мэргэжилтэн бэлтгэх тогтолцооны шинэчлэл, тулгамдаж буй асуудал, гарц шийдлийн талаар сургалтын байгууллагын багш, удирдах ажилтнуудыг оролцуулсан холбогдох арга хэмжээ, сургалт, семинарыг зохион байгуулах, хууль, журам, дүрмийг сурталчлан таниулах.	байгуулж хууль, журам, дүрмийг сурталчлан таниулсан байна.		байгуулж хууль, журам, дүрмийг сурталчлан таниулсан байна.	боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнуудад яамнаас хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа, цаг үеийн мэдээлэл хүргэх, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөөг танилцуулах хурал, уулзалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ, сургалт семинаруудад оролцож чиг үүрэгт хамаарах мэдээлэл судалгааг бэлтгэн танилцуулга хийсэн. Тухайлбал, Монголын Багш нарын 8-р их хурал, Сургалтын байгууллагын захирал, хягтлан бодогч, сургалтын менежерүүдийг шинэчилсэн хуулийн дагуу чадавхижуулах семинар, Нийгмийн түншлэл, хосмог сургалтын чиглэлээр чадавхижуулах сургалт, аймаг орон нутгийн Боловсролын газар, хэлтсийн мэргэжлийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	---	--	--	---

					боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах семинар, сургалт, Сургалтын байгууллагын удирдлагуудад цаг үеийн мэдээлэл танилцуулах хурал, мөн ГОУХАН-тэй хамтран Мэргэжлийн багш, үйлдвэрлэлийн дадлагажуулагчийг өндөр хүчдэлийн техникийн хосмог сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулж МБСБ-ын мэргэжлийн багш нар, Эрчим хүчний сургалтын төвийн багш нар, Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн компаниудын сургалтын инженер, үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нар, боловсролын үнэлгээний төвийн албан хаагчдыг хамруулсан. Эдгээр танхим болон цахимаар салбарын хэмжээнд зохион		
--	--	--	--	--	--	--	--

					байгуулсан томоохон сургалт, семинар, арга хэмжээнүүдэд чиг үүрэгт хамаарах сэдвээр мэдээлэл бэлтгэн танилцуулах, хууль тогтоомж, журам дүрмийг танилцуулах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Мөн Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгийн политехник коллеж, Сүхбаатар аймаг, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг зохион байгуулж аймаг, орон нутагт газрын даргын хамт ажиллаж энэ үеэр сургуулийн удирдлага, багш ажилчидтай уулзалт хийж, салбарын бодлого үйл ажиллагаа, дүрэм журмыг танилцуулж, санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган		
--	--	--	--	--	---	--	--

					ажилласан. Хавсралт: 15 файл		
--	--	--	--	--	---------------------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Мэргэжил, мэргэшлийн чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдахын зэрэгцээ бие даан мэдлэг чадвараа хөгжүүлнэ.	Яам болон холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдахын зэрэгцээ бие даан мэдлэг чадвараа дээшлүүлнэ.	-	Яам болон холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдахын зэрэгцээ бие даан мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	БНХАУ-ын Бээжин, Шанхай хотод 2024 оны 09 сарын 22-27-нд мэргэжлийн боловсролын хосмог сургалтын туршлага судлах арга хэмжээнд оролцсон. Энэ хүрээнд БНХАУ-ын Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүний нөөц, сургалт судалгаа, үнэлгээний газар, Мэргэжлийн боловсролын хөгжлийн төв, БНХАУ, ХБНГУ-ын хамтарсан “Тунжи” их сургууль, “Тай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					Цан” хосмог сургалтын төв, Герман компаниудын гишүүнчлэлтэй АНК академи зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. Мөн Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн МБС-ийн үйл ажиллагаатай танилцаж хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд зөвлөн туслах, удирдлага, арга зүйгээр хангах зорилгоор газрын даргын хамт 2024 оны 10 дугаар сарын 21-нээс 25-нд орон нутгуудад ажилласан. Төрийн албан хэрэг хөтлөлтийг Монгол үндэсний бичгээр хөтлөхтэй холбоотой Монгол бичгийн мэдлэг чадвараа бие даан сайжруулахад анхаарч ажиллав. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт Канад Улсын Засгийн газрын дэмжлэгээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төслийн ажилтныг Барилгын политехник коллеж, Налайх политехник коллежийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг		
--	--	--	--	--	--	--	--

					зохион байгуулж, сургалтын байгууллагын талаар мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Мөн Боловсролын яам болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан "Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага", "Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам", "Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын өөрийн үнэлгээний асуумж", "Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө" боловсруулах ажлын хэсэг, "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын үндсэн чиглэл (2024-2028) боловсруулах" ажлын хэсэг, Эрүүл мэндийн яам, ГБХНХЯ-тай хамтарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулахад дэмжих төвийн дүрэм		
--	--	--	--	--	--	--	--

					боловсруулах ажлын хэсэгт тус тус гишүүнээр ажиллав. Хавсралт: 28 файл		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хосмог сургалт, хөдөлмөр эрхлэлт, суралцагчийн хөгжлийн асуудал хариуцсан шинжээч, Энхболд Эрдэнэбилэг

/...../

Огноо: